

**БАТЛАВ  
ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**



**Х.НЯМБААТАР**

2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр

## **АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтад Төрийн албанд захирах, захирагдах ёсыг баримтлахаар заасныг хэрэгжүүлэх, түүнчлэн Улсын Их Хурлын шийдвэрээр удирдлагыг нь томилдог байгууллагын дэд даргыг тухайн байгууллагын дарга томилж байгаа жишгийг, тухайлбал, Статистикийн тухай хуулийн 13<sup>1</sup> дүгээр зүйлийн 13<sup>1.1</sup> дэх хэсэгт Үндэсний статистикийн хороо Дэд даргатай байх ба Дэд даргыг Үндэсний статистикийн хорооны дарга томилохоор заасан зэргийг харгалзан Авлигатай тэмцэх газрын дэд даргыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилохоор заасан Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн зохицуулалтыг өөрчилж, тус газрын дарга томилохоор тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасны дагуу Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байх бөгөөд уг хуулийн төсөлд Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулж, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилдог байсныг өөрчилж, зөвхөн тус газрын даргыг Улсын Их Хурал томилохоор, дэд даргыг тус газрын дарга томилохоор тусгана.

Авлигатай тэмцэх газрын дэд даргыг тус газрын дарга томилохтой холбогдуулан дэд даргыг улируулан томилох, чөлөөлөх, түдгэлзүүлэх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, Засгийн газрын гишүүнтэй адил бүрэн эрхийн баталгаа, хангамжтай холбоотой зохицуулалтад холбогдох өөрчлөлтийг оруулахаар тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал**

Хуулийн төслийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн ямар нэг сөрөг үр дагавар гарахгүй.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд уг хуулийн төсөлтэй уялдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй бөгөөд Авлигатай тэмцэх газрын дэд даргыг тус газрын дарга томилохоор тусгахтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл тогтоох тухай” 19 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл боловсруулна.

---oOo---